

МУИС-ИЙН ОЮУТНЫ ДАДЛАГЫН ЕРӨНХИЙ ЖУРАМ¹

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Бакалаврын сургалтын төлөвлөгөөнд заавал судлах хичээл хэлбэрээр тусгагдсан, сургалтын технологийн горимын дагуу хийвэл зохих дадлагыг зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.² Дадлагын чанар, үр дүнг дээшлүүлэх, бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны болон мэргэжлийн тэнхмийн эрхлэгч/профессорын багийн ахлагч, дадлага удирдах багшийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, багш оюутны эрх, үүргийг тодотгох, дадлагын гүйцэтгэлд өгөх үнэлгээ, дүгнэлтийг боловсронгуй болгоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Оюутан танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх чадвар, дадал эзэмших, өөрийн мэргэжлийн салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл олж авах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг эзэмших зорилготой суралцах үйл ажиллагааг *дадлага* гэнэ.
- 1.3 Дадлага нь үндсэн хичээлтэйгээ хамт юмуу тусдаа багц цагтай байна. Нэг багц цагийн хэмжээ нь 16 долоо хоногтой улирлын хувьд 48 цагтай тэнцүү байна.
- 1.4 Дадлагын төрөл, зорилго, мэргэжлийн онцлогоос хамааруулан хөтөлбөрийг нь энэхүү ерөнхий журмын хүрээнд мэргэжлийн тэнхмийн эрхлэгч/профессорын багийн ахлагч хариуцан боловсруулж, бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр батлуулан хичээлийн жилийн эхэнд сургалтын мэдээллийн систем, "Оюутны гарын авлага"-д оруулсан байна.
- 1.5 Дадлагын хөтөлбөрт нэр, индекс, багц цаг, урьдчилсан шаардлага, зорилго, оюутны эзэмших мэдлэг, чадвар, дадал, хандлагын агуулга, үнэлгээ, ашиглавал зохих ном, сурах бичиг, бусад материалын жагсаалтыг тусгахаас гадна дадлагын хугацаа, зохион байгуулах хэлбэр, дадлага хийх газар, маршрут, ажлын болон амралтын цаг, аюулгүй ажиллагааны нөхцөл, тайлангийн бүтэц зэргийг тодотгосон байна.
- 1.6 МУИС нь оюутны дадлага хийх практик сургалтын төв/лаборатори, полигон, түнш аж ахуйн нэгж, байгууллага, тогтсон маршруттай байна.

Хоёр. Дадлагын төрөл

- 2.1 Оюутны дадлага нь дараах төрлүүдтэй байж болно. Үүнд:
 - Үйлдвэрлэлийн;
 - Хээрийн;
 - Сурган хүмүүжүүлэх.Мөн, дадлагын зорилго, шаардлагаас үүдэн хээрийн-үйлдвэрлэлийн дадлага гэх мэт холимог хэлбэртэй байж болно.
- 2.2 Оюутны танхимд эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик мэдлэг, чадвар, дадлаар баяжуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага дээр зохион байгуулах дадлагыг *үйлдвэрлэлийн дадлага* гэнэ. Энэ төрлийн дадлага нь танилцах эсвэл мэргэшүүлэх зорилготой байна.
 - 2.2.1 Оюутны мэргэжлийн суурь хичээлээр эзэмшсэн онолын мэдлэгт түшиглэн практик үйл ажиллагаанд ажиглалт хийлгэх, цаашид мэргэших чиглэлийг нь сонгуулах, мэргэшүүлэх хичээл судлуулах, дараагийн шатанд мэргэшүүлэх зорилготой

¹ Захирлын 2003/665 тоот тушаалаар баталж, 2005/117 тоот тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан журмын шинэчилсэн найруулга.

² Сурган хүмүүжүүлэх дадлагын журмыг тусгайлан гаргаж, мөрдүүлнэ.

дадлага хийлгэх урьдчилсан нөхцлийг хангах зорилгоор үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулах ба мэргэжлийн тэнхим/профессорын багаас томилсон багш оюутны бүлгээр удирдана. Ийм зорилготой үйлдвэрлэлийн дадлага нь мэргэжлийн чиглэл, дадлагыг явуулах газраас хамааран дараах үндсэн чиглэлүүдтэй байна. Үүнд:

а) Аж ахуйн нэгж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, хэлбэр, зохицуулалт, тухайн мэргэжлийн онцлог, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээтэй танилцах, дүн шинжилгээ хийх,

б) Хээрийн нөхцөлд газар, ус, хөрс, ургамал, амьтан, эрдэс чулуулгийн тогтоц, бүтэц, шинж чанарын нийтлэг зүй тогтолд ажиглалт, тэмдэглэл хөтлөх,

в) Суурин болон хээрийн нөхцөлд соёл иргэншил, хөшөө дурсгал, булш бунхан зэрэг археологи, соёл, түүхийн дурсгалт зүйлийг үзэж, ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөх зэрэг болно.

2.2.2 Тухайн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөн дэх мэргэшүүлэх хичээлийн дийлэнхийг оюутан амжилттай судалсны дараа эзэмшиж буй мэргэжлийнх нь чиглэлээр мэргэшүүлэх, ажлын арга барилд суралцуулах, мэргэжлийн ёс зүйн хандлага төлөвшүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулна. Энэ тохиолдолд оюутан тэнхим/профессорын багаас томилсон багш, аж ахуйн нэгж, байгууллагаас томилсон мэргэжилтний хамтын удирдлагын дор дадлага хийнэ.

2.2.3 Бүрэлдэхүүн сургууль дэргэдээ үйлдвэрлэлийн дадлагын орчныг бүрдүүлсэн практик сургалтын төвтэй нөхцөлд сургууль дээрээ дадлагыг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд дадлагын үргэлжлэх хугацааг төв сургалтын албатай зөвшилцөн тогтоох ба мэргэжлийн тэнхим/профессорын багаас томилсон багш дадлагыг удирдан явуулна.

2.3 Оюутанд хөрс, ус, ургамал, амьтан, чулуулаг зэрэг байгалийн нөөц, археологи, соёл, түүхийн дурсгалуудын хээрийн судалгааны ажиглалт, туршилтын арга зүйг эзэмшүүлэх, онолын мэдлэгийг нь практик дээр бататгах, байгалийн нөөц, археологийн олдворыг бие даан тодорхойлж, боловсруулах, дээжийг нь сургалтын үзүүлэн таниулах болон судалгааны материал болгон бэлтгэх чадвар, дадал эзэмшүүлэх зорилгоор хөдөө орон нутагт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий байгалийн тогтоц газар, түүх соёлын дурсгалт газар, полигонд зохион байгуулагдах дадлагыг *хээрийн дадлага* гэнэ. Хээрийн дадлагаар оюутанд дээр дурдсан чадвар, дадлыг эзэмшүүлэхийн зэрэгцээ хээрийн нөхцөлд ажиллаж, амьдрах, байгаль орчинтой зөв харьцах ажиллагаанд сургана.

2.3.1 Хээрийн дадлага тогтсон маршруттай байна. Маршрутыг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулсан байвал зохино.

2.3.2 Хээрийн дадлагыг оюутны бүлгээр мэргэжлийн тэнхим/профессорын багаас томилсон багшийн шууд удирдлагын дор хийнэ.

2.3.3 Оюутны бие даан гүйцэтгэх чадварыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн хээрийн дадлага хийх гарын авлагыг тусад нь бэлтгэсэн байвал зохино. Уг гарын авлагад байгалийн нөөц, археологийн олдворыг эрж хайх, малтах, дээжид нь ажиглалт, харьцуулалт, сонголт, анхан шатны боловсруулалт хийх, баримтжуулах, ялган таних зэрэг хээрийн нөхцөлд бүтэц, онцлог шинжээр нь задлан шинжилж бичиглэл, зураглал хийх түгээмэл, нийтлэг арга зүй, боох, хадгалах, тээвэрлэх аргууд болон манай оронд өргөн тархсан, дадлагын үед хамгийн ихээр тохиолдож болох тухайн бүлгийн олдворыг таних түлхүүр бичиг, зураг, заавар, зөвлөмж зэргийг оруулсан байна.

2.3.4 Хээрийн дадлагаар цуглуулсан дээжийн сонголт нь лабораторийн нөхцөлд үргэлжлүүлэн судалж бие даалтын болон бакалаврын судалгааны ажил хийхэд эх материал болгон ашиглагдах боломжтой байна.

2.4 *Сурган хүмүүжүүлэх дадлага* нь оюутанд мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүй, дидактикийн хичээлүүдээр эзэмшсэн мэдлэг, чадвараа багшлах үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх арга зүйг эзэмшүүлэх үндсэн зорилготой.

2.4.1 Сурган хүмүүжүүлэх дадлагыг ерөнхий боловсролын сургууль (ЕБС) дээр хийнэ. ЕБС-д холбогдох хичээл нь заагддаггүй мэргэжлээр хийх дадлагыг их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв дээр хийж болно.

2.4.2 Сурган хүмүүжүүлэх дадлагыг мэргэжлийн тэнхим/профессорын багийн болон Сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухааны тэнхмийн багш нар тухайн дадлага хийгдэх сургуулиас томилогдсон багштай хамтран удирдана.

Гурав. Дадлагыг зохион байгуулах

3.1 Дадлагыг оюутны танхимд судалсан нэг буюу бүлэг хичээлийн агуулгаар зохион байгуулна.

3.2 Дадлага хийх газар нь уг хичээлийн зорилгоос хамааран үйлдвэр, аж ахуйн газар, сургалт, эрдэм шинжилгээний чиглэлийн төрийн ба төрийн бус байгууллага, төсөл, хөтөлбөр болон шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий байгалийн тогтоц газар, түүх соёлын дурсгалт газар гэх мэт байж болно.

3.3 Бүрэлдэхүүн сургууль оюутны дадлага хийлгэх аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалт гаргаж, шаардлагатай гэж үзвэл түншлэлийн гэрээ байгуулна. Олон мэргэжлийн салбар хамаарах түнш байгууллагатай оюутны дадлага хийлгэх тухай гэрээг МУИС-ийн захиргаа хийж болно.

3.4 Оюутныг өөрийн байгууллага дээр дадлага хийлгэх хүсэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг Оюутанд үйлчлэх төв хүлээн авч бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаар дамжуулан мэргэжлийн тэнхим/профессорын багт уламжилж, ажлын хоёр долоо хоногт багтаан шийдвэрлүүлнэ.

3.5 Дадлагыг оюутны бүлгээр зохион байгуулахыг чухалчлах боловч дадлага хүлээж авах газрын онцлог, хүчин чадлаас хамааран ганцаарчилсан байдлаар хийхийг зөвшөөрнө.

3.6 Дадлагыг зохион байгуулахдаа бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба аж ахуйн нэгж, байгууллагатай оюутныг оролцуулан гурван талын гэрээ байгуулна (Үлгэрчилсэн гэрээ: Хавсралт 1).

3.7 Дадлагад гарах багш, оюутан эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамрагдсан байх бөгөөд түүнийг өөрсдөө хариуцна.

Дөрөв. Бүрэлдэхүүн сургуулийн эрх, үүрэг

4.1 Бүрэлдэхүүн сургууль дадлагыг зохион байгуулахад шаардагдах эрх зүйн болон материаллаг нөхцлийг бүрдүүлэхэд санаачлага гаргаж, зохион байгуулалт, үр дүнд хяналт тавьж ажиллана.

4.2 Дадлага хийх оюутны нэр, сургуулиас болон аж ахуйн нэгж, байгууллагаас удирдах багш, мэргэжилтэн, холбогдох төсвийг мэргэжлийн тэнхим/профессорын багийн хурлаар хэлэлцэж, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албаар хянуулан, захирлын тушаалаар баталгаажуулсан байна. Зардлыг төлөвлөхдөө сургуулийн Санхүү, эдийн засгийн хэлтсээс гаргасан нэгдсэн жишгийг баримтлах бөгөөд тухайн үеийн бараа, үйлчилгээний үнэлгээг тооцно.

4.3 Бүрэлдэхүүн сургууль сургалтын төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа дадлагын батлагдсан төсвийг захиран зарцуулах эрх эдэлнэ.

4.4 Хөдөө орон нутагт багш, оюутан явуулж хээрийн дадлага хийх тохиолдолд нийтийн тээврийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагаас олгосон хүн тээвэрлэх

зөвшөөрөлтэй, техникийн хувьд бүрэн бүтэн тээврийн хэрэгсэл, хээрийн нөхцөлд ажиллах дадлага туршлагатай жолоочийг сонгож, үйлчилгээний гэрээ байгуулна (Үлгэрчилсэн гэрээ: Хавсралт 3).

- 4.5 Бүрэлдэхүүн сургууль хичээлийн жилийн явцад үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан төв сургалтын албатай зөвшилцөж дадлагын хугацааг хойшлуулах, урагшлуулах, онцгой тохиолдолд богиносгох эрх эдэлнэ.
- 4.6 Оюутныг цалинтай дадлага хийлгэх, урамшуулах боломжийг эрэлхийлэн, дэмжиж ажиллана.
- 4.7 Дадлагын үед ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, МУИС-ийн дотоод дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Дадлага удирдагчийн эрх, үүрэг

- 5.1 Бүрэлдэхүүн сургуулиас оюутны дадлагыг удирдах багшийн эрх, үүрэг
 - 5.1.1 Дадлага эхлэхээс өмнө уг дадлагын хөтөлбөр буюу дадлагын зорилго, оюутны эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, гүйцэтгэх ажлын хэмжээ, дадлагын үед баримтлах дэг журам, хээрийн нөхцөлд мөрдөх аюулгүй ажиллагааны заавар болон бусад асуудлыг оюутанд танилцуулж, гарын үсэг зуруулсан байна.
 - 5.1.2 Дадлагыг хөтөлбөрийн дагуу удирдан явуулах, оюутанд зөвлөн туслах (дадлагын хичээлийн хөтөлбөрт дадлагыг удирдах багшийн оюутантай ажиллах ажиллагааг тодорхой тусгах), хяналт тавихын зэрэгцээ оюутан, аж ахуйн нэгж байгууллагаас дадлагыг удирдах мэргэжилтэн нарыг холбож өгөх үүрэг хүлээнэ.
 - 5.1.3 Ганцаарчилан дадлага хийж буй оюутантай байнгын харилцаатай байж, шаардлагатай бөгөөд боломжтой бол газар дээр нь дадлагын байдалтай нь танилцаж, зөвлөгөө өгөх зэргээр дадлагын явцад хяналт тавьж ажиллана.
 - 5.1.4 Хөдөө орон нутагт дадлага удирдах багш тогтоосон маршрутаар явж, томилолтын хуудсаа орон нутгийн захиргааны байгууллагаар бөглүүлсэн байна.
 - 5.1.5 Хээрийн дадлагын үед дархан цаазтай газарт нэвтрэх, шаардагдах хэмжээгээр ан амьтан агнах, ховор ургамал, шавьжийн цуглуулга бэлтгэх, археологийн малтлага хийх зэрэгт зохих хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл авсан байна. Мөн хээрийн дадлагын үед байгаль орчныг хамгаалах талаар тусгай төлөвлөгөө боловсруулан, тухайн газрын байгаль орчин хариуцсан мэргэжилтнээр батлуулан ажиллана.
 - 5.1.6 Тухайн дадлагыг хийхэд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудаас шаардлагатай заалтуудыг оюутнуудад уншиж танилцуулах буюу түүвэрлэн авч танилцуулга бэлтгэн оюутанд хүргэсэн байна.
 - 5.1.7 Оюутны дадлагын үр дүнд тодорхойлолт, үнэлгээ өгч, тайланг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын тушаалаар томилогдсон комиссын гишүүдийн хамт хамгаалуулна.
 - 5.1.8 “МУИС-ийн багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-д заасны дагуу ажлаа үнэлүүлэн дүгнүүлж, багц цаг тооцуулна.
- 5.2 Аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулахдаа оюутны дадлагыг удирдах мэргэжилтний эрх, үүргийн талаар дараах зүйлсийг тусгана. Үүнд:
 - 5.2.1 Дадлага хийх оюутныг хүлээн авч, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод дүрэм журам, үйл ажиллагаатай танилцуулж, оюутны анхаарвал зохих зүйлсийн талаар зөвлөгөө өгч, аюулгүй байдлыг нь хариуцан ажиллах,
 - 5.2.2 Дадлагыг хөтөлбөрийн дагуу удирдан явуулах, оюутанд зөвлөн туслах, хяналт тавих,
 - 5.2.3 Бүрэлдэхүүн сургуулиас оюутны дадлагыг удирдах багштай байнгын холбоотой байж, оюутны дадлага хийж буй байдлын талаар харилцан зөвшилцөж, үр дүнтэй хамтран ажиллах,

5.2.4 Оюутны дадлагын үр дүнд тодорхойлолт, үнэлгээ өгөх,

5.2.5 Дадлага удирдсан мэргэжилтэнд тооцох **цагийн доод хэмжээ** дараах жишигтэй байх ба МУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан багшид олгох цагийн хөлсний хэмжээг тогтоосон тарифаар ажлын хөлс олгоно. Үүнд:

а) Мэргэшүүлэх зорилготой үйлдвэрлэлийн дадлагын 1-5 оюутныг удирдахад 7 хоногт оюутан бүрийн 3 цаг, 5-аас дээш оюутан бүрд 1 цаг тооцно.

б) Танилцах зорилготой үйлдвэрлэлийн дадлагын 1-5 оюутныг удирдахад 7 хоногт 8 цаг, 5-аас дээш оюутан бүрд 0.5 цаг тооцно.

Тооцох цагийн хэмжээг хоёр талын хооронд байгуулах гэрээний хүрээнд бүрэлдэхүүн сургуулийн Захирлын тушаалаар тусгайлан зохицуулж болно.

Зургаа. Оюутны эрх, үүрэг

- 6.1 Оюутан тухайн дадлагад хамрагдахаас өмнө судалсан байвал зохих хичээлүүдийг амжилттай судалж, шаардлагатай багц цагийг цуглуулсан тохиолдолд дадлага хийнэ.
- 6.2 Дадлага эхлэхээс өмнө дадлагын хөтөлбөртэй танилцсан байна.
- 6.3 Дадлагыг хөтөлбөрийн дагуу гүйцэтгэх ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, удирдах багш, аж ахуйн нэгж байгууллагаас оюутныг удирдахаар томилогдсон мэргэжилтнээр батлуулж, ажиллана.
- 6.4 Дадлагын явцад тухайн байгууллагын үйл ажиллагаанаас өөрт холбогдох үйл ажиллагаатай сайтар танилцаж, ажиглалт хийн тэмдэглэл хөтөлж, шаардлагатай ажил үүргийг гүйцэтгэнэ (Дадлагын тэмдэглэл, тооцооны эх материалыг тайланд хавсаргана).
- 6.5 Оюутан өөрийн сонгосон, тухайн мэргэжлийн холбогдолтой сэдэв/асуудлаар бие даалтын ажил/төсөл хийж үр дүнг нь бусад оюутныг байлцуулан, удирдагч багшийн удирдлагын дор хэлэлцүүлнэ.
- 6.6 Дадлага хийх явцдаа өөрийн санаачилгаар дадлагажиж байгаа үйл ажиллагаатай холбоотойгоор хичээлийн хөтөлбөрт заагаагүй ажлуудыг нэмж гүйцэтгэж болно.
- 6.7 Тухайн мэргэжлийн хөдөлмөрийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг судалж мэдсэн байна.
- 6.8 Байгууллагын дотоод дүрэм, журамд захирагдаж ажиллахын сацуу байгууллагын мэдээллийн нууцыг задруулахгүй байж, баримтыг алдаж үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлж ажиллана. Баримт, материалтай танилцахдаа удирдаж буй мэргэжилтнээс болон эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байвал зохино. Мөн баримтыг гадагш авч явах зэргээр байгууллагын ажилд хүндрэл учруулахгүй байхаас гадна ажилтнуудтай ёс зүйн хэм хэмжээг сахиж соёлтой харилцана.
- 6.9 Дадлага хийж буй газартаа сургуулиа сурталчлах, эрдэм дэлгэрүүлэн соёл түгээж, үлгэр жишээч байх ёстой.
- 6.10 Ганцаарчилсан дадлага хийж байгаа оюутан дадлагын хугацаанд удирдаж буй багштай байнгын холбоотой ажиллана.

Долоо. Дадлагын хичээлийн үнэлгээ, тайлан хамгаалалт

- 7.1 Оюутны дадлагын хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, дадал, хандлагыг 100 оноогоор үнэлэх ба бүтцийг нь мэргэшүүлэх зорилготой үйлдвэрлэлийн дадлагын хувьд үлгэрчилсэн байдлаар авч үзвэл дараах байдалтай байх ба бүрэлдэхүүн хэсэг бүрээс оюутны авах онооны задаргаа, тавигдах шаардлагыг дадлагын хичээлийн хөтөлбөрт дэлгэрэнгүй тусгана. Үүнд:
 - Оюутан *дадлагажих ажлын гүйцэтгэлээс* нийт онооны 40 хувийг авна. Гүйцэтгэлийг оюутны ажилласан цагийн бүртгэл, удирдаж буй багшийн хийсэн үечилсэн хяналт, шалгалтын дүн, ажил олгогчоос (буюу удирдсан мэргэжилтнээс)

өгсөн тодорхойлолт, үнэлгээг харгалзан гаргана. Удирдсан мэргэжилтэн оюутанд өгөх тодорхойлолт, үнэлгээгээ тухайн байгууллагын албан бичгийн хуудсан дээр бичиж, гарын үсгээ зурсан байх ба дарга/захирлын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Тодорхойлолтод удирдсан мэргэжилтний албан тушаал, овог, нэрийг тодорхой бичсэн байх шаардлагатай.

- Оюутан сонгож авсан, тухайн мэргэжлийн холбогдолтой сэдэв/асуудлаар шаардлагатай тоо, мэдээ, баримтыг цуглуулан *2-оос доошгүй бие даалтын ажил/төсөл* хийж үр дүнг нь удирдагч багшийн удирдлагын дор ангид хэлэлцүүлэх ба үүнээс авбал зохих нийт онооны 30 хувийг авна. Эдгээр бие даалтын ажил, хэлэлцүүлэг нь оюутнуудад дадлагаар эзэмшиж буй мэдлэг, чадвараа харилцан хуваалцах, танхимд үзсэн онол, үзэл баримтлалуудыг дадлагын ажлаараа турших зэрэг боломжийг олгоно.
- Оюутан *дадлагын тайлангаас* авбал зохих нийт онооны 30 хувийг авна. Тайланг оюутан тухайн дадлагын хөтөлбөрт тусгасан загвар, шаардлагын дагуу бичиж, дадлага дууссанаас хойш долоо хоногийн дотор харьяалагдах мэргэжлийн тэнхим/профессорын багт ирүүлнэ. Тайлан гурван үндсэн хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт дадлагын хүрээнд оюутны зүгээс дэвшүүлэн тавьсан зорилго, зорилт, хийхээр төлөвлөсөн ажлыг, хоёр дахь хэсэгт дадлага хийсэн байгууллага, түүний зорилго, үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлчлүүлэгч, бүтэц зохион байгуулалт, оюутны дадлагажих ажлын байр, тэрхүү ажлын байрны тухайн байгууллагад гүйцэтгэдэг үүрэг, бусад ажлын байртай уялдах уялдаа холбоо зэргийг, сүүлийн хэсэгт тайлангийн нэгдүгээр хэсэгт тусгасан зорилго, зорилт, хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг тусгана. Дадлага дууссанаас хойш нэг сарын дотор (хэрэв зуны амралтын хугацаа таарвал 9-р сард) бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар батлагдсан комисст оюутан бүр дадлагын эцсийн үр дүн, тайланг хамгаална. Комисс оюутнаас танхимд үзсэн онолын мэдлэгээ практикт хэрэглэх чадварыг шалгах асуултад хариулт авч, харилцан ярилцаж, гүйцэтгэлийг нь дадлагын хөтөлбөртэй харьцуулан үнэлгээгээ гаргана.

- 7.2 Оюутан амжилттай дүн ($\geq 60\%$) авбал дадлагын багц цагийг тооцно. Удирдсан багш оюутны авсан дүнг тайлан хамгаалалтаас хойш ажлын 5 хоногийн дотор сургалтын мэдээллийн системд оруулан, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас оюутны нэрс, дүн бүхий хуудсыг авч, хянан, гарын үсгээр баталгаажуулан хүлээлгэж өгнө.
- 7.3 Дадлага хийсэн боловч эцсийн тайлангаа амжилттай хамгаалж чадаагүй оюутан дахин хамгаалах ба дадлагын хөтөлбөрт заасан ажлуудыг гүйцэтгээгүй бол өөрийн зардлаар дадлагыг нөхөн хийж, тайлан хамгаална.
- 7.4 Оюутан хүндэтгэх шалтгааны улмаас цөөн хоногоор дадлагад гарч чадаагүй бол тухайн дадлагын үлдсэн хугацаанд нөхөн хийхийг зөвшөөрнө. Дадлага хийсэн хугацаа нийт хугацааны 2/3-оос бага байвал дадлагын үлдсэн хугацаанд нөхөн хийх боломжгүй гэж үзэж дадлага хийгээгүйд тооцно.

Найм. Дадлагыг зохион байгуулахад баримтлах аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага

- 8.1 Дадлага нь хот, хөдөөд болон гадаадад, аж ахуйн нэгж, байгууллага дээр зэрэг хаана ч явагдсан тухайн орчинд нь оюутан аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой.
- 8.2 Аюулгүй ажиллагааны дор дурдсан нийтлэг шаардлагуудыг тусган, дадлага хийгдэх объект, орчин, хэрэглэгдэх арга хэрэгсэл, осолд хүргэж болзошгүй хүчин зүйлс зэрэг онцлогийг харгалзсан аюулгүй ажиллагааны тодорхой зааврыг дадлагын хөтөлбөрт холбогдох мэргэжлийн тэнхим/профессорын баг тусган, мөрдүүлнэ.
- 8.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга зүйг оюутан бүр мэдсэн байх ёстой. Үүнд:
- 8.3.1 Дадлагын үед ашиглах багаж төхөөрөмжийн ажиллагааны зааврыг судалсан байна.

- 8.3.2 Аюулгүй ажиллах арга барил эзэмшсэн, аюул тохиолдсон үед түүний хор хөнөөлийг яаралтай зайлуулах арга хэмжээг авахад суралцсан байна.
- 8.4 Дадлагын хөтөлбөр дэх аюулгүй ажиллагааны зааварт дараах зүйлсийг тодорхой тусгасан байна. Үүнд:
- 8.4.1 Үер, шуурга, аянга, газар хөдлөлт, гал түймэр зэрэг байгалийн гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх,
- 8.4.2 Могой, хачиг зэрэг хор хүргэж болох амьтнаас сэргийлэх, шаардлага гарсан үед анхны тусламж үзүүлэх,
- 8.4.3 Машин жолоодох, усанд сэлэх, хад асганд авирах зэрэг дадлагын хөтөлбөрт заагдаагүй бөгөөд аюул осолд хүргэж болох аливаа үйлдэл хийхийг хориглох,
- 8.4.4 Ил задгай гал түлэхгүй байх, нүүдэллэх үед цог, нурмыг унтраах,
- 8.4.5 Гол усанд хувцас хунар, сав суулга угаах, удаан задардаг хог хаях зэргээр байгаль орчныг бохирдуулахыг хориглох,
- 8.4.6 Түүх, соёл, байгалийн дурсгалт зүйлсийг хамгаалах.
- 8.5 Аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрдүүлэх талаар дараах арга хэмжээ авна. Үүнд:
- 8.5.1 Удирдагч багш дадлагын үед баримтлах аюулгүй ажиллагааны зааврыг оюутнуудад танилцуулж, тэмдэглэл хөтөлсөн байх,
- 8.5.2 Оюутнууд аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын заавартай танилцсан тухайгаа гарын үсэг зурж баталгаажуулсан байх (Үлгэрчилсэн загвар:Хавсралт 2),
- 8.5.3 Багш оюутнуудад хөдөлмөр зохион байгуулалтын ерөнхий зааварчлага өгөхөөс гадна хээрийн дадлагын талбайд гарах бүрт заавар өгөх,
- 8.5.4 Нэн шаардлагатай эм, ороох боох материал, дулаан хувцас, ариун цэврийн хэрэглэлтэй байх,
- 8.5.5 Хөдөө орон нутагт дадлага удирдаж буй багш дадлагын зорилго, маршрутаа орон нутгийн захиргаа, хэв журам сахиулах албанд мэдэгдэх, тухайн газар нутгийн тогтоц, зам даваа, гол усны онцлогийн талаар орон нутгийн байгууллага, иргэдээс мэдээлэл авч, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд тэднээс тусламж авах,
- 8.5.6 Хээрийн дадлагын батлагдсан хугацаа, маршрутыг баримтлах, гарцаагүй өөрчлөх үед байршлаа бүрэлдэхүүн сургуулийн захиргаанд мэдээлж байх,
- 8.5.7 Багш өөрийн болон бусдын хүүхэд, гэр бүлийн хүмүүс зэрэг дадлагад хамааралгүй хүнийг хамт авч явах, замын хүнийг өөрсдийн унаанд дайх, унаа саатсан үед оюутныг замын унаанд дайж явуулахыг хориглох,
- 8.5.8 Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа хээрийн дадлага хийх оюутныг тээвэрлэх машин, жолоочийг сонгож, гэрээ байгуулах (Үлгэрчилсэн гэрээ: Хавсралт 3).

ДАДЛАГЫН ГУРВАЛСАН ГЭРЭЭ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль болох _____, түүнийг төлөөлөн тус сургуулийн Сургалтын албаны эрхлэгч _____ /цаашид “бүрэлдэхүүн сургууль” гэх/, нөгөө талаас _____ (төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж), түүнийг төлөөлж _____ /цаашид “дадлагыг хүлээн авах байгууллага” гэх/, гуравдагч талаас тус сургуулийн _____ мэргэжлийн ____ -р түвшний оюутан _____ овогтой _____ /цаашид “дадлагажигч оюутан” гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Гэрээний зорилго оюутны танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон гүнзгийрүүлж, баяжуулах, оюутанд мэргэжлийн салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл олж авах боломж олгох, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг эзэмшүүлэх, дадлагыг хавсралтан дахь хөтөлбөрийн дагуу зохион байгуулах, дадлагыг хүлээж авах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Дадлагыг хүлээж авах байгууллагын эрх, үүрэг

- 2.1.1 Оюутны дадлагыг удирдах мэдлэг, туршлагатай мэргэжилтнийг удирдагчаар томилно.
- 2.1.2 Оюутныг дадлагын хөтөлбөрийг биелүүлэхэд шаардагдах материал, ажил болон ажлын өрөө тасалгаа зэрэг дадлагажих нөхцөл бололцоогоор хангана.
- 2.1.3 Шаардлага гарвал дадлагажигч оюутны зөвшөөрлөөр түр орон тоогоор цалинжуулан ажиллуулж болно. Гэхдээ энэ нь зааж сургах үйл ажиллагааг орхигдуулахгүй, оюутны суралцах цагт нөлөөлөхгүй байх ёстой.

2.2 Дадлагын хичээлийг удирдах мэргэжилтний эрх, үүрэг

- 2.2.1 Оюутныг практикийн болон мэргэжлийн ёс зүйн хувьд удирдан дадлагажуулж, дадлагын хөтөлбөрт заасан чадвар, дадлыг эзэмшихэд туслана.
- 2.2.2 Оюутанд дадлагыг хүлээж авсан байгууллагын дотоод журам, холбогдох хууль тогтоомжийг танилцуулан, мөрдөж ажиллахыг шаардана.
- 2.2.3 Тухайн байгууллагын нууцад хамаарахаас бусад дадлага хийхэд шаардагдах байгууллагын үйл ажиллагааны талаарх болон бусад мэдээллийг олж авахад нь туслана.
- 2.2.4 Удирдагч нь дадлагын явцыг баримтжуулж, үнэлгээ өгөх ба дадлага хийж дууссаны дараа дадлага хийсэн тухай, дадлагын ажлын үнэлгээний санал бүхий тодорхойлолтыг гаргаж өгнө.
- 2.2.5 Удирдагч мэргэжилтэн нь дадлага удирдсаны хөлсийг зохих журмынхаа дагуу тооцон олгохыг бүрэлдэхүүн сургуулиас шаардах эрхтэй.

2.3 Дадлагажигч оюутны эрх, үүрэг

- 2.3.1 Хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөн, дадлагажуулах зорилгоор даалгаж байгаа ажлыг хугацаанд нь, өгсөн чиглэлийнх нь дагуу бүрэн гүйцэтгэх үүрэг хүлээнэ.
- 2.3.2 Байгууллагын талаас томилогдсон мэргэжилтний удирдлага дор ажиллана.
- 2.3.3 Шаардлагатай үед дадлагын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг өгнө.

2.3.4 Дадлагажих явцад олж мэдсэн хувь хүн, байгууллагын талаархи мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

2.3.5 Дадлагыг гэрээнд хавсаргасан хөтөлбөрийн дагуу явуулах, шаардлагатай мэдээллээр хангах, тодорхой арга барилд сургахыг удирдагчаас шаардах эрхтэй.

2.3.6 Талуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

2.4 Бүрэлдэхүүн сургуулийн эрх, үүрэг

2.4.1 Оюутан болон дадлагын удирдагч мэргэжилтийг гүйцэтгэх ажлын тодорхой удирдамжаар хангана.

2.4.2 Дадлагын явцад хяналт тавина. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулж болохгүй.

2.4.3 Дадлагын удирдагчийн хөлсийг дадлага хүлээн авсан байгууллага, удирдагч мэргэжилтнээс өгсөн нэхэмжлэхийг үндэслэн зохих журмын дагуу төлөх үүрэг хүлээнэ.

ГУРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

3.1. Бүрэлдэхүүн сургуулиас удирдаж буй багш дадлага шаардлага хангахгүй байна гэж үзээд үүнийг нь дадлагажигч оюутны дэмжиж байвал гэрээг цуцлах тухай санал гаргаж болно. Ийнхүү гарсан саналыг дадлагыг хүлээж авсан байгууллага, удирдагч мэргэжилтэнтэй тохиролцож шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хөлс төлөгдөхгүй.

3.2. Дадлагажигч оюутны буруутай үйл ажиллагааны улмаас гэрээ цуцлагдсан тохиолдолд дадлагыг нөхөн хийлгэнэ.

ДӨРӨВ. ГЭРЭЭ ХУЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ

4.1. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

МУИС-ийн бүрэлдэхүүний _____ сургуулийг төлөөлж _____
/гарын үсэг: _____/

Хаяг: _____

_____ байгууллагын _____ ажилтай
_____ /гарын үсэг: _____/

Хаяг: _____

_____ мэргэжлийн _____-р түвшний оюутан _____
/гарын үсэг: _____/

Хаяг: _____

Огноо: _____

**Оюутанд дадлагын хөтөлбөр, журам, дадлагын үед баримтлах
аюулгүй ажиллагааны шаардлагыг танилцуулсан хяналтын хуудас**

Бүрэлдэхүүн сургууль, тэнхим: _____

Мэргэжил, оюутны сурч буй түвшин: _____

Дадлагын нэр, индекс: _____

Дадлагын эхлэх, дуусах хугацаа: _____

Удирдагч багш: _____ /гарын үсэг: _____/

Огноо: _____

Танилцуулсан хичээлийн хөтөлбөр, журам, заавар:

Бусад хууль, тогтоомж:

Хичээлийн хөтөлбөр, дадлагын журам, аюулгүй ажиллагааны шаардлага, арга зүйтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн оюутны нэр, гарын үсэг зуруулсан тухай баримтыг хүснэгтээр гаргана.

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монгол Улсын Иргэний хуулийн 380 дугаар зүйлийн 380.1 дэх заалтыг үндэслэн нэг талаас тээвэрлүүлэгч МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль болох _____, түүнийг төлөөлөн тус сургуулийн захирал _____, тэнхмийн эрхлэгч _____, дадлагыг удирдагч багш _____, /цаашид “бүрэлдэхүүн сургууль” гэх/, нөгөө талаас тус сургуулийн _____ мэргэжлийн __-р түвшний оюутныг хөдөө орон нутагт дадлага хийхэд багш, оюутныг тээвэрлэгч _____ овогтой _____ нар дараах нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Оюутныг дадлагын хөтөлбөрт заагдсан хугацаа ба маршрутаар __км замд __хоног тээвэрлэхэд жолоочид ажлын хөлсийг хоногт __төгрөгөөр, шатахууны үнийг 100 км-т __ төгрөгөөр бодож (үнэлгээг тухайн үеийн зах зээлийн ханшаар бодно), гүйцэтгэлээр тооцохоор харилцан тохиролцов.

ХОЁР. ЖОЛООЧИЙН ҮҮРЭГ

- 2.1. Хүн тээвэрлэх эрхтэй, ангилал тохирсон байх;
- 2.2. Зорчигч тээврийн газраас зөвшөөрөл авах ;
- 2.3. 5-аас доошгүй жил зорчигч тээвэрлэсэн туршлагатай байх ;
- 2.4. Техникийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулсан албан ёсны зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авах;
- 2.5. Машин нь бүрхүүлтэй, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг хангасан байх ;
- 2.6. Дадлагын удирдагчийн өгсөн үүрэг, зааварчилгааны дагуу ажиллах;
- 2.7. Даваа, гүвээ, хэт хазгай газар зэрэг аюултай замд зорчигчдыг буулгаж гаргах;
- 2.8. Илүү шатахуун тээвэрлэх шаардлагатай бол битүүмжлэл сайтай, хөдөлгөөнгүй бэхэлж аюулгүй байдлыг хангах;
- 2.9. Хурд, даац хэтрүүлэхгүй байх;
- 2.10. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байх;
- 2.11. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй болон ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх;
- 2.12. Шөнийн цагаар явахгүй байх;
- 2.13. Хоногт 240 км буюу 8 цагаас илүү явахгүй байх, тасралтгүй 100 км-ээс илүү явахгүй байх;
- 2.14. Бусдад жолоогоо шилжүүлэхгүй байх;
- 2.15. Кабинд нормоос илүү хүн суулгахгүй байх, зөвшөөрөлгүй газраар явахгүй байх.

ГУРАВ. ЖОЛООЧИЙН ЭРХ

- 3.1. МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд жолооч хөдөлгөөн эхлэхгүй байх;
- 3.2. Тээвэрлэж байгаа багш, оюутнаас хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахыг шаардах;
- 3.3. Тогтоосон тооноос илүү багш, оюутан болон дадлагын хичээлд үл хамаарах (тушаалд нэр заагдаагүй) хүн тээвэрлэхээс татгалзах;
- 3.4. Зорчигчийн буруутай үйл ажиллагаа, түүнчлэн авч яваа ачаа, тээш болон бусад эд хөрөнгөөс шалтгаалж өөрт учирсан хохирлыг зорчигчоос шаардах.

ДӨРӨВ. МУИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ҮҮРЭГ

- 4.1. Дадлагаар орон нутагт явах маршрутыг тодорхой гаргаж баталсан байх;

- 4.2. Хээрийн дадлагад явах оюутны нэрсийг захирлын тушаалаар баталсан байх;
- 4.3. Дадлагад явах багш нар болон бүх оюутныг эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулсан байх;
- 4.4. Жолоочид төлөх хөлсийг зохих тарифийн дагуу (Хэрэглэгдэх шатахууны үнийн 60%, ажлын хөлсний 40%-ийг дадлагын хичээлд гарахын өмнө, шатахууны үнийн үлдэх хэсгийг нийт замын хагасыг явсны дараа, ажлын хөлсний үлдэх хэсгийг дадлагын хичээл дууссаны дараа бэлнээр олгоно) төлөх;

ТАВ. МУИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ЭРХ

- 5.1. Урьдчилан мэдэх боломжгүй байсан бөгөөд мэдсэн тохиолдолд гэрээг хийхгүй байх шалтгаан болохоор нөхцөл байдал тээвэрлэгчийн зүгээс илэрсэн, түүнчлэн гэрээнд заасан газарт хүрч очих болон замд явах хугацаа хожимдох магадлал байгаа тохиолдолд тээвэрлүүлэгч гэрээ байгуулахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй.
- 5.2. Дадлагын явцад тээвэрлэгчийн гэм буруугаас гэрээний нөхцөл зөрчигдвөл үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах, гэрээг цуцлах эрхтэй.
- 5.3. Тээвэрлэгч болон бусад ажилтнуудын үйл ажиллагааны дутагдал, тээврийн хэрэгслийн бүрэн бус ажиллагаа, эвдрэл, эд материалын доголдол, дутагдал зэргээс зорчигчид учирсан хохирлыг тээвэрлэгч болон харьяа байгууллагаас шаардах эрхтэй.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1. Шатахуун, ажлын хөлсний төлбөрийг гэрээнд заасан ёсоор төлөөгүйгээс гарсан саатлыг МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль хүлээх ба жолоочийн өөрийн буруугаас болж гарсан бусад хохирлыг тээвэрлэгч хариуцна.
- 6.2. Зорчигч нь өөрийн буруутай үйл ажиллагаа, түүнчлэн авч яваа ачаа, тээш болон бусад эд хөрөнгөөс шалтгаалж тээвэрлэгчид учирсан хохирлыг хариуцна.
- 6.3. Тээвэрлэлтийн явцад зорчигчид өөрт нь буюу түүний эд хөрөнгөд гэм хор учирсан, авч яваа зүйл нь алдагдсан, гэмтсэн бол тээвэрлэгч хууль болон тодорхой төрлийн тээврийн дүрэмд заасан хариуцлага хүлээнэ.
- 6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл зорчигчийн буруугаас буюу түүний авч явсан зүйлээс шалтгаалж гэм хор учирсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй.
- 6.5. Тээвэрлэгч болон бусад ажилтнуудын үйл ажиллагааны дутагдал, тээврийн хэрэгслийн бүрэн бус ажиллагаа, эвдрэл, эд материалын доголдол, дутагдал зэргээс зорчигчид хохирол учирсан нь тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.6. Гэрээ байгуулагч аль нэг тал гэрээг зөрчсөний улмаас үүссэн маргааныг эв зүйгээр зохицуулахыг хичээх бөгөөд хэрэв эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй бол хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 7.1. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Тээвэрийн хэрэгсэл ашиглагч:

Захирал:

_____ / гарын үсэг: _____ /

Дадлага удирдсан багш:

Тээвэрлэгч:

_____ / гарын үсэг: _____ /

Тээвэрлэгчийн харилцах хаяг:

Машины улсын дугаар: _____

/ гарын үсэг: _____ /
Тэнхимийн эрхлэгч:

/ гарын үсэг: _____ /
Хаяг: _____

Огноо:

Машины марк: _____
Байнгын хаяг: _____

Утас: _____
Байгууллагад харьяалагддаг бол
байгууллагын нэр:

Байгууллагын утас: _____